



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 1036

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Нийслэлийн Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Нийслэлийн Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч намын хорооноос Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр /.../...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ

2024.04.24

Улаанбаатар

Батлав: ЭЧХН-ын Боловсруулан Зөвлөлдөх Ерөнхий Хороо


нэгдүгээр хавсралт

УРИА: ИРГЭДДЭЭ ЭЭЛТЭЙ НИЙСЛЭЛИЙГ БҮТЭЭХИЙН ТУЛД БИД ХИЙНЭ, БИД БҮТЭЭНЭ.

НИЙСЛЭЛЧҮҮДЭЭРЭЭ ШИЙДҮҮЛНЭ.

Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам Нийслэлийн намын хорооноос сонгуульд оролцох мөрийн хөиөлбөр Үүнд:

1. Нийслэлийнхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэхийн төлөө тууштай байж зорилгоосоо буцахгүй ажиллана.
2. Нийслэлчүүдийн эрх ашигт харшилсан хуулиудыг хүчингүй болгож, иргэд, байгууллагын хуулийн төслийн тухай саналыг дэмжиж ажиллана.
3. Нийслэлчүүдийн хөгжлийн өвөрмөц загварыг хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна.
4. Нийслэлд хүний эрх, эрх чөлөө, эрх үүрэг, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг дотооддоо ч гадаадад ч хамгаалан ажиллана.
5. Нийслэлчүүдийн хүүхэд, залуучуудад уламжлалт түүхэн өв соёл, эх оронч боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, оюуны өмчийг хөгжүүлнэ.
6. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэн агаарын бохирдлыг арилгахын тулд олон тулгуурт эрчим хүчийг ашиглаж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор иргэдийн хяналтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бий болгоно.
7. Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг үр хүүхэд, хойч үедээ нандигнан өвлүүлэх ажлыг бага наснаас нь сургаж хэвшүүлнэ.
8. Дотоодын аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагчдын татварын тогтолцоонд улс эх орны эрх ашигт нийцсэн эрх зүйн орчинг бий болгоно.
9. Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж ард түмэндээ хэрэглээ болгон, эх орондоо хэвшүүлэн хөгжүүлнэ.



НИЙСЛЭЛИЙН НАМЫН ДАРГА *B. Batmunkh* Б.БАТМӨНХ



Batmunkh